



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 01/53 ЧАТ/САТ/2014/37-ЛТТ

Зөрчил арилгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Монгол Улс Олон улсын валютын сангийн /ОУВС/ гишүүн орны хувьд тус санд оруулсан хөрөнгө, авч ашигласан зээлийн хөрөнгийг тэдний шаардлагын дагуу бүртгэл, тайланд тусгаж, баталгаажуулж байх үүргийг бусад гишүүн орны нэгэн адил хүлээдэг.

Монгол Улсаас ОУВС-д оруулсан хөрөнгө, авч ашигласан зээлийн хөрөнгийг Монголбанк Олон улсын валютын сангаас тавьдаг шаардлагын дагуу 2011 он хүртэл бүртгэж, Сангийн яам нийт дүнгээр нь Монголбанктай тооцоо нийлж, тайланд бүртгэлд тусгаж байжээ.

Монголбанкны 2011 оны санхүүгийн тайланд аудит хийсэн "ПрайсВатерХаусКуперс" компани тус банкны тайлан, тэнцэлд бүртгэлтэй ОУВС-гийн холбогдох хөрөнгө, зээлүүдийг бүртгэлээс хасч, ОУВС-гийн санхүүгийн зуучлагч /Fiscal agent/ болох Сангийн яаманд бүртгэлийг шилжүүлэхийг зөвлөмж болгосон байна.

Дээрх зөвлөмжийн дагуу Монголбанк ОУВС-тай холбоотой бүртгэл, тооцоог санхүүгийн тайлангаасаа хасч, Сангийн яаманд шилжүүлэх явцад үүссэн 148,464,703.0 төгрөгийн тооцоог Монголбанкинд шилжүүлж, ОУВС-аас авлагаар (нөөц хөрөнгө) бүртгэх асуудлыг Сангийн яаманд удаа дараа тавьсан боловч шийдвэрлээгүй байна.

Сангийн яамны Төрийн сангийн газар ОУВС-д оруулсан хувь оролцоо, Стэнд-бай хөтөлбөрийн зээлийг санхүүгийн тайландаа нийт дүнгээр нь бүртгэдэг боловч ОУВС-гийн зааврын дагуу дансдыг зориулалтаар нь ангилан бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1-д заасан "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалттай зөрчилдөж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

Үүнд:

1. Монголбанкнаас ОУВС-гийн бүртгэлийг шилжүүлэн авсантай холбогдуулан үүссэн 148,464,703.0 төгрөгийг Монголбанкинд шилжүүлж, тус сангаас авлага хэлбэрээр бүртгэх.
2. Монгол Улсаас ОУВС-д оруулсан хөрөнгө, авч ашигласан зээлийн хөрөнгийг ОУВС-гаас тавьсан шаардлагын дагуу дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, тайлагнах боломж нөхцлийг бүрдүүлж, 2014 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн сангийн санхүүгийн тайланд залруулга хийх.
3. Дээрх албан шаардлагын биелэлтийг хангаж, 2014 оны 12 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Санхүү бодлого, өрийн удирдлагын газрын дарга Б.Нямаа, Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил нарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР



Ж.БАТСАЙХАН